



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 4/256

Улаанбаатар хот


Г Журам батлах тухай Т

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын 2.4.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа шатлалын тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх журмыг нэгдүгээр, эмнэлэгт иргэнийг илгээх цахим бүртгэлийн цэсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), Эмнэлгийн тусlamжийн газар (М.Баттүвшин), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Д.Ганцэцэг) –д тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга болон өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (Б.Баярт)-т даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний шатлал, шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх тогтолцооны загвар батлах тухай” 2009 оны 307 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081110

Эруул мэндийн сайдын
2018 оны 06 сарын 28 өдрийн
1 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ИРГЭНИЙГ
ЭМНЭЛГИЙН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ЭМНЭЛЭГТ ИЛГЭЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмыг эмнэлгийн яаралтай тусlamж, үйлчилгээ авахаас бусад тохиолдолд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага хооронд иргэнийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр шилжүүлэх, эргэх холбоо тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад дагаж мөрдөнө.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллага хооронд иргэнийг шилжүүлэх үйлчилгээний бүртгэл мэдээлэлд цахим бүртгэл болон цаасан маягтыг ашиглана.
- 1.3. Иргэн эрүүл мэндийн байгууллагыг өөрийн хүсэлтээр сонгож үйлчлүүлэхэд энэ журмаар зохицуулагдахгүй.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. "Илгээх" гэж эрүүл мэндийн байгууллага хооронд иргэнийг эмнэлзүйн заавар, удирдамж, журамд үндэслэн оношилгоо, шинжилгээ, үзлэг, эмчилгээ хийлгэхээр шилжүүлэх үйлчилгээг;
- 2.2. "Цаг товлох" гэж иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх кабинет, эмчийн үзлэгийн цагийн тов олгохыг;
- 2.3. "Хүлээн авах" гэж үзлэгийн товлогдсон хугацаанд иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийг;
- 2.4. "Эргэх холбоо тогтоох" гэж шилжүүлэн авсан иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг илгээсэн байгууллагад буцаан хүргүүлэхийг хэлнэ.
- 2.5. "Иргэнийг илгээх цахим дугаар" /цаашид цахим дугаар гэх/ гэж өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээс олгох дахин давтагдахгүй тоон өгөгдлийг хэлнэ.

Гурав. Иргэнийг илгээх ба эргэх холбоо тогтоох

- 3.1. Лавлагaa шатлалын эрүүл мэндийн байгууллагад иргэнийг илгээх:
 - 3.1.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, амаржих газар, клиникт өвчний оношилгоо, эмчилгээний зааврын дагуу илгээх;
 - 3.1.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, амаржих газар, клиник болон шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас өвчний эмнэлзүйн заавар, удирдамж, журмын дагуу иргэний лавлагaa шатлалын эмнэлэгт илгээх;
 - 3.1.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс лавлагaa шатлалын эмнэлэгт өмнө нь үзүүлж онош нь тодорсон, давтан эмчилгээ хийлгэх шаардлагатай иргэнийг, мөн аймгийн төвөөс хэт алслагдсан эсвэл яаралтай шилжүүлэх шаардлагатай тохиолдолд шууд илгээх;

- 3.2. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас эргэх холбоо тогтоох:
 - 3.2.1. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага нь илгээсэн иргэнийг товлосон хугацаанд хүлээн авч, тусlamж, үйлчилгээг үзүүлэх;
 - 3.2.2. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас иргэнийг илгээсэн эрүүл мэндийн төв болон бусад эрүүл мэндийн байгууллагын хяналтад заавал буцаан илгээх ба зөвлөмж өгч, тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах.

Дөрөв. Шилжүүлгийн цахим бүртгэлийн үйлчилгээ

- 4.1. Шилжүүлгийн цахим үйлчилгээ нь интернетэд суурilan, тухайн байгууллагад ашиглагдаж байгаа H-info болон вебд суурилсан бусад програм байна.
- 4.2. Цахим бүртгэлд нэвтрэх тусгай эрх, эмчийн хувийн дугаарыг орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн газраас, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс авна.
- 4.3. Эмчийн хувийн дугаар давтагдахгүй байна.
- 4.4. Цахим бүртгэлийн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийг тухайн эрүүл мэндийн байгууллагын дотоод журмаар зохицуулна.
- 4.5. Цахим шилжүүлэг нь "Эмнэлэгт иргэнийг илгээх цахим бүртгэл"-ийн цэс /цаашид шилжүүлгийн цахим бүртгэл гэх/-ийн дагуу хөтлөгднө.
- 4.6. Шилжүүлгийн цахим бүртгэл нь ашиглах заавартай байна.
- 4.7. Шилжүүлгийн цахим бүртгэл нь иргэний 6 орон бүхий цахим хяналтын дугаараар баталгаажна.
- 4.8. Шилжүүлгийн цахим бүртгэлд дараах үйл ажиллагааг хамруулна.
 - 4.8.1 "Илгээх" - иргэнийг хүлээн авах байгууллагыг сонгож цахим бүртгэлд бүртгэх;
 - 4.8.2 "Цаг товлох" - цахим бүртгэлд бүртгүүлсэн иргэнийг хүлээн авч байгаа эмнэлэгт үзүүлэх өдөр, цаг, кабинетийг товлож баталгаажуулах;
 - 4.8.3 "Хүлээн авах" - иргэнийг товлосон цагт хүлээн авч тусlamж, үйлчилгээ үзүүлэн эмчийн дүгнэлтийг цахим хуудсанд тэмдэглэх;
 - 4.8.4 "Эргэх холбоо тогтоох" - эмчлэгч эмчийн зөвлөмжийг тэмдэглэн, харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд шилжүүлэх, иргэнийг өрх, сум, тосгоны эмч хүлээн авч эрүүл мэндийн байдлыг хянах.
- 4.9. Иргэний хүсэлтээр цахим бүртгэлийн хуудсыг хэвлэн өгч болно. Хэвлэж өгсөн цахим бүртгэлийн хуудас нь Эрүүл мэндийн бүртгэлийн маягт AM-13 маягтай адил хүчинтэй байна.

Тав. Шилжүүлгийн цаасан бүртгэлийн үйлчилгээ

- 5.1. Цахим сүлжээ хязгаарлагдмал байгаа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь батлагдсан Эрүүл мэндийн бүртгэлийн маягт AM-13 "Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас"-ыг /цаашид AM-13 маягт гэх/ ашиглан үйлчлүүлэгчийг шилжүүлнэ.
- 5.2. Цахим сүлжээ ашиглалтад орох хүртэл, эсвэл бусад онцгой тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэнийг AM-13 маягт ашиглан шилжүүлж болно.
- 5.3. Эрүүл мэндийн байгууллага хооронд AM-13 маягтаар шилжиж байгаа иргэний үзүүлэх өдөр, цагийг утсаар товлож өгнө.

Зургаа. Иргэнийг илгээх байгууллагын эрх, үүрэг

- 6.1. Иргэнийг илгээх эрүүл мэндийн байгууллага нь хүлээн авах байгууллагын үйлчилгээний төрөл, чиглэл, онцлог, тусlamж үйлчилгээний төлбөр, эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллээр хангаж, иргэнд эмнэлгийг сонгоход нь туслалцаа үзүүлнэ.
- 6.2. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн "Илгээх" хэсэгт бичилт хийж үзлэгийн өдөр, цагийн товыг сонгох, баталгаажилтад эмч хяналт тавина. Бүртгэлийн "Илгээх" хэсгийг хэвлэж өгч болно.
- 6.3. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн "Илгээх" хэсэгт шилжүүлэх шалтгааныг сонгож, нэмэлт мэдээллийг бусад гэсэн хэсэгт дэлгэрэнгүй бичих ба энэ нь хүлээн авагч байгууллагын иргэнийг хүлээн авч тусlamж, үйлчилгээ үзүүлэх үндэслэл болно.
- 6.4. Үзлэгийн цаг товлол, үзүүлэх кабинет, бүрдүүлэх бичиг баримтыг иргэн, эсвэл түүний асран хамгаалагчид тодорхой тайлбарлан өгч хүлээн авагч эрүүл мэндийн байгууллага руу илгээнэ.
- 6.5. Иргэний хүсэлтээр эмчийн үзлэгийн товыг 24-48 цагийн өмнө өөрчлөх болон цуцалж болно.
- 6.6. Хэвтэн эмчлүүлж байгаа иргэнийг яаралтайгаас бусад тохиолдолд шилжүүлэхэд хүлээн авах эмнэлгийн эмч настай утсаар зөвлөлдөх эсвэл цахим зөвлөгөөн хийсний дараа гаргасан шийдвэрийг үндэслэн шилжүүлнэ.
- 6.7. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн "Эргэх холбоо тогтоох" хэсгийн дагуу иргэнийг буцаан хүлээн авч хянана.
- 6.8. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс "Иргэнийг илгээх цахим дугаар"-ыг олгоно.

Долоо. Иргэнийг хүлээн авах байгууллагын эрх, үүрэг

- 7.1. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн "Цаг товлох" хэсэгт бичилт хийж баталгаажуулна.
- 7.2. Иргэнийг хүлээн авах тов өөрчлөгдөх тохиолдолд цахим хуудсанд тэмдэглэж, иргэнд урьдчилан 24-48 цагийн өмнө утсаар мэдэгдэнэ.
- 7.3. Иргэнд тусlamж, үйлчилгээ үзүүлсний дараа шилжүүлгийн цахим бүртгэлийн "Хүлээн авах" хэсэгт бичилт хийнэ.
- 7.4. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлд цаг товлосон иргэн үзлэгийн кабинет хооронд шилжин тусlamж, үйлчилгээ авах тохиолдолд тухайн өдөрт багтаан иргэнд цаг товлож, үзлэгт нь хяналт тавина.
- 7.5. Товлосон үзлэгийн кабинетийн эмчийн үзлэг хойшлогдсон тохиолдолд тухайн өдөртөө багтаан цагийг дахин товлон үзлэгийг зохицуулна.
- 7.6. Орон нутгаас ирсэн иргэнийг хэвтүүлэн эмчлэх шаардлагатай бол орны хүлээлгийг богино хугацаанд зохицуулалт хийж, тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.
- 7.7. Иргэнд тусlamж, үйлчилгээг үзүүлсний дараа шилжүүлгийн цахим бүртгэлийн "Эргэх холбоо тогтоох" хэсэгт бичилт хийж, зөвлөгөө өгч, илгээсэн байгууллагын хяналтад шилжүүлж, тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана.

Найм. Иргэний эрх, үүрэг

- 8.1. Иргэн өөрийн регистрийн дугаар, түлхүүр үгээр цахим бүртгэлд нэвтэрч, цаг товлолыг харах боломжтой байна.

- 8.2. Иргэн цаг товполыг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ цахим хаяг болон утасны дугаарыг ашиглан тухайн эмнэлэгт 24-48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 8.3. Иргэн хувийн шалтгаанаар тухайн товлосон цагт эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадаагүй бол өөрөө дахин цаг товлол авна. Энэ тохиолдолд илгээгч эрүүл мэндийн байгууллага хариуцлага хүлээхгүй.
- 8.4. Иргэн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн хүлээн авагч эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлнэ.

Ес. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрх, үүрэг

- 9.1. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн програм хангамжийн тогтвортой үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангана.
- 9.2. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн програм ашиглах арга зүйгээр хангаж, мэргэжилтнийг бэлтгэнэ.
- 9.3. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлтэй холбоотой эрүүл мэндийн тоон үзүүлэлтийг гаргах, цахим шилжүүлгийн явц, шилжүүлгийн хүлээгдлийн хугацаа, цахим шилжүүлгийн үр дүнгийн талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

Арав. Эрүүл мэндийн газрын эрх, үүрэг

- 10.1. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн програм ашиглах арга зүйгээр хангах, хэрэглээний талаарх сургалт зохион байгуулж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллана.
- 10.2. Иргэнийг шилжүүлэх цахим бүртгэлийн тоон мэдээнд дүгнэлт хийж жилийн эцэст нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 28. өдрийн
A/256 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЭМНЭЛЭГТ ИРГЭНИЙГ ИЛГЭЭХ ЦАХИМ БҮРТГЭЛИЙН ЦЭС

Паспортын хэсэг

1. Иргэний овог _____ Нэр _____ Нас _____

РД

ЭМД

Цахим №

2.Хүйс (сонго) 1. эрэгтэй 2. эмэгтэй

3. Иргэний утас _____ гар утас _____ цахим хаяг _____

4.Иргэний (асран хамгаалагчийн) утас _____ гар утас _____ цахим хаяг _____

5. Иргэний гэрийн /тогтмол/ хаяг:

“Илгээх” хэсэг

6.Илгээж байгаа байгууллагын нэр (сонго).....код /автоматаар гарч ирнэ/

7.Илгээсэнон.....сар.....өдөр.....цаг.....минут

8.Эмчилгэч эмчийн нэрхувийн дугаар

9.Хүлээн авах байгууллагын нэр (сонго).....

10.Иргэнийг илгээж байгаа шалтгаан (сонго)

- Онош тодруулах /сонго/
- Урьдчилан сэргийлэх үзлэг /сонго/
- Эмчилгээ /сонго/
- Эмчилгээний дараах хяналт /сонго/
- Жирэмсний болон төрөх үеийн тусlamж, үйлчилгээ
- Хөнгөвчлөх эмчилгээ
- Сэргээн засах тусlamж, үйлчилгээ
- Сувилахуйн тусlamж, үйлчилгээ
- Давтан хяналт
- Бусад: /тодорхой бичих/

11.Үндсэн онош (Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу дэлгэрэнгүй бичнэ) _____/сонго/

Хавсарсан онош /сонго/ _____

Хавсарсан онош /сонго/ _____

Хавсарсан онош /сонго/ _____

Хавсарсан онош /сонго/ _____

Тайлбар /бичих/ _____

12. Шилжүүлэх болсон шалтгааныг үндэслэх шинжилгээ (програмын өгөгдлийг бөглөнө)

ЦЕШ /сонгох/ _____

Биохими /сонгох/ _____

ШЕШ /сонгох/ _____

Рентген /эмчийн хариуг бичих/ _____

Бусад /MRI, KTG/_/эмчийн хариуг бичих/ _____

“Цаг товлох” хэсэг

13. Хүлээн авах эсэх шийдвэр (сонго) 1.тийм 2.үгүй
- 14.Хэрэв тийм бол үзлэгийн кабинетын нэртасгийн нэр /сонго/
- 15.Хэрэв үгүй бол тайлбар, үндэслэл (сонго)
 - тухайн эмнэлэгт тусламж, үйлчилгээ авах боломжгүй
 - бусад /бичих/
16. Шийдвэр гаргасанон.....сар.....өдөр.....цаг.....минут
- 17.Товлосонсар.....өдөр.....цаг

“Хүлээн авах” хэсэг

18. Хүлээн авсан сар.....өдөр.....цагХүлээн авах эмчийн нэр
.....
19. Хүлээн авсан: Үндсэн онош (Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу дэлгэрэнгүй бичнэ)
_____Хавсарсан онош
/сонго/
_____Хавсарсан онош /сонго/
20. Эмчлүүлсэн: Үндсэн онош (Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу дэлгэрэнгүй бичнэ)
_____Хавсарсан онош
/сонго/
_____Хавсарсан онош /сонго/
- 21.Эмнэлэгт хэвтсэн ор хоног /сонго/

- 22.Эмнэлгээс гарсан огноо, цаг
(сонго)
- 23.Эмнэлгээс гараж үеийн дүгнэлт
(эпикриз)/бичих/
- 24.Эмчлэгч эмчийн нэр.....утасны дугаар....., цахим
хаяг.....

“Эргэх холбоо тогтоох” хэсэг

25. Илгээсэн байгууллагад өгөх зөвлөмж /бичих/
26. Зөвлөмжийг хүлээн авсан огнооон.....сар.....өдөр.....цаг.....минут
27. Иргэнийг хяналтад авсан эсэх (сонго) 1.тийм 2. үгүй
28. Иргэнийг хяналтад авсан эмчийн нэрутасцахим хаяг